



**ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 03 сарын 14 өдөр

Дугаар А/131

Хэрлэн сум

**Аймгийн шуурхай штабын үйл
ажиллагааны зардалд хөрөнгө зарцуулах тухай**


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1. Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3. Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3 дахь заалт, Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2 дугаар зүйлийн 2.1.6, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 63 дугаар тогтоол, Улсын онцгой комиссын даргын 2023 оны 8 дугаар тулаалыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ НЬ:**

1.Өвөлжилт, хаваржилтыг даван туулах, аймаг, сумын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах зорилгоор байгуулагдсан аймгийн шуурхай штабын үйл ажиллагааны зардалд 958,000 (есэн зуун тавин найман мянган) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2.Зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

3.Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

Аймгийн Засаг даргын 2024 оны
03 дугаар сарын 14-ны
дугаар захирамжийн хавсралт

ШААРДАГДАХ ТООЦОО

д/д	Зардлын төрөл	Тоо ширхэг	Мөнгөн дүн
1	Аккумулятор	2	520.000
2	Клем	1	8.000
3	Ажлын зураг	1	280.000
4	ОК-ын принтерын засвар	-	150.000
	Нийт		958.000